



**“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын
24- ны өдөр

Дугаар 01.20

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9-дэх хэсэг, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.20 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.20 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2886994 саналаар буюу 100.0 %-ийн саналаар Компанийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг, 2886994 саналаар буюу 100.0 %-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ -өөс өгсөн дүгнэлтийг батласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ТУЗ-д ажлаа дүгнүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.

Хурлын дарга



Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Ч.Энхцэцэг



**“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын
24-ны өдөр

Дугаар 02.20

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож,
батлах тухай.

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.20 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/20 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив
2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Д.Мөнхбатыг,
2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар С.Алимааг,
2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Б.Ёндонжамцыг,
2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Д.Гиваапилийг,
2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Х.Ханияг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,
Кумулятав 2886989 санал буюу 33.33 %-ийн саналаар Б.Аюушийг,
2886989 санал буюу 33.33 %-ийн саналаар Э.Бямбажавыг
2886989 санал буюу 33.33 %-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгосныг баталсугай.

2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (С.Мөнхжаргал)- д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр сарын
24-ны өдөр

Дугаар 03.20

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах
тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, Компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 07.20 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.20 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.20 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2886989 саналаар буюу 100.0 %-ийн саналаар 2019 оны цэвэр ашгийн 60%-иар, нэгж хувьцаанд 38.92 ₮-өөр тогтоосугай.
2. Ногдол ашигт зарцуулагдах 130,98 сая.төг- (нэг зуун гучин сая есөн зуун наян мянган)-ийг компанийн ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөрсүгэй.
3. Компанийн мөнгөн гүйлгээний боломжтой үед зохицуулан, 2020 оны 6 дугаар сар Ногдол ашгийг нийтэд зарлан, тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг



**“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын
24- ны өдөр

Дугаар 04.20

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 хэсэг, хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.20 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.20 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2886981 санал буюу ердийн олонхийн 100.0 %-ийн саналаар 55510.0 мян.₮ (тавин таван сая таван зуун арван мянган)- өөр хавсралтын дагуу баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга (С.Мөнхжрагал) –д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг



**“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын
24- ны өдөр

Дугаар 05.20

Улаанбаатар хот

Компанийн хаягийн өөрчлөлтийг
тусгаж шинэчилсэн дүрмийг
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дүгээр хэсэг, 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.20 тоот тогтоол, хувьцаа эзэмшигч дийн хурлын Т-1.20 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ариг гал” ХК-ийн оршин байрлах хаягыг “Хан-Уул” дүүрэг.19 дугаар хороо. Зайсан гудамж. Үйлдвэрийн парк 18-1 тоот гэж баталсуай.

2. Компанийн дүрэмд компанийн оршин байрлах хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн оршин байрлах хаягийн өөрчлөлт оруулан баталсан дүрэмд хууль, журмын дагуу СХЗ-нд оруулж зохих зөвшөөрлийг авсны үндсэн дээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст оруулан бүртгүүлэх, бүртгэгдсэн дүрмийг СХЗ-нд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг